



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



JAPAN INTERNATIONAL
COOPERATION AGENCY

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (DPUB)

Мэдээллийн эмхэтгэл No.24 (2019 он 2-р сар)

Япон улс, Окинава мужид зохион байгуулагдсан

“Хөгжлийн бэрхшээлийн салбарын манлайлагч бэлтгэх” сэдэвт сургалтын мэдээллүүд

Япон дахь сургалт эхэллээ (2019.01.26)



1/20-ны өдөр эхэлсэн Япон дахь сургалт 2 долоон хоногийн хугацаанд үргэлжилнэ. Сургалт Японы хамгийн өмнөд захын арал болох Окинава мужид зохион байгуулагдаж байгаа юм. Хамгийн эхний хичээлийг энэ удаагийн сургалтын ахлагчаар ажиллаж буй Такаминэ Ютака багш заалаа. Такаминэ багш ахлах сургуульд байхдаа бэртэл авч, нуруу нугасны гэмтэлтэй болсон бөгөөд 50 гаруй жил тэргэнцэр хэрэглэж байна. Тэрээр гадаадад магистрын зэрэг хамгаалж, бие даан амьдрах хөдөлгөөн эхлүүлэх зэргээр Япон дахь ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр идэвхтэй ажиллаж ирсэн. Мөн НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн Эдийн засаг-Нийгмийн комисс (ESCAP)-т хөгжлийн бэрхшээл хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байсан ба Окинава мужид буцаж ирснийхээ дараа их сургуульд багшлахын сацуу Empowerment Okinawa ТББ-ыг байгуулжээ. Одоо ЖАЙКА-ийн шугамаар ирсэн суралцагчдыг хүлээн авч Япон улс болон Окинава мужийн туршлага, өөрийн мэдсэн сурсанаа бусадтай хуваалцаж байна. Такаминэ багш оролцогчдод хандан “Намайг бэртэл авсан тухайн үед сургуульд сурах ч хүндрэлтэй байсан. Түүнээс хойш өнөөг хүртэлх 50 жилийн хугацаанд дэлхий даяар ч тэр Японд ч тэр олон дэвшил гарсан. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө хүчин чармайлт гарган ажиллах нь хамгийн чухал байдаг. Та бүхэн ч гэсэн нутагтаа буцаж очсоныхоо дараа холбогдох үйл ажиллагаануудыг эхлүүлснээр Монгол Улс хурдан хугацаанд өөрчлөгдөх боломжтой.” хэмээн ярьж байлаа.

Окинава муж дахь DET сургалт (2019.01.31)

Монгол болон Окинава мужийн DET сургагч багш нар Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын талаар мэдээлэл солилцлоо. Энэ удаагийн сургалтанд оролцож буй хөгжлийн бэрхшээлтэй 5 хүн бүгд DET сургагч багш нар юм. Тэдний хувьд Улаанбаатар хот төдийгүй хөдөө орон нутагт руу чиглэсэн үйл ажиллагаануудыг ч явуулж байгаа. Окинава дахь сургагч багш Кобаяши нь тус мужид сургалт явуулаад 3 жил болж байгаа юм байна. Улаанбаатар хоттой ойролцоо хүн амтай Окинава мужид тэрээр ганцаараа DET сургагч багшаар ажилладаг. DET сургалтыг ганцаараа явуулахад хүндрэлтэй. Тиймээс дэмжих тогтолцоог нэвтрүүлэн, бичиг хэргийн ажилтан зэргийг оруулаад 10 хүнтэй баг бүрдүүлжээ. Тэд багаараа өнөөг хүртэл 75 удаагийн сургалт зохион байгуулж 1600 хүнийг хамруулжээ. Сургагч багш нар Кобаяшигаас “DET сургалт нь 3 цагийн хугацаатай урт сургалт. Та бүхэн богиносгосон хугацаатай сургалт хийдэг үү?” хэмээн асууж байсан ба тэрээр “Хамгийн чухал нь оролцогчидтой харилцан ярилцах явдал. Окинавад энэ сургалтыг 3,5 цагийн хугацаатай хийдэг. Тийм учраас хэрвээ цаг хангалтгүй байгаа тохиолдолд агуулгыг 2 хувааж хийх талаар сургалт өгч буй талтайгаа зөвлөлддөг” гэж байв. Итгэлийг хүлээсэн боловсролын байгууллага болох зорилт тавин ажиллаж байна. Сурах бичиг боловсруулах, хүүхдүүдэд чиглэсэн сургалт гэх мэтээр олон шинэ зүйлд сорилт хийн ажиллаж буй түүнээс сургалтын оролцогчид маань урам зориг авч чадсан гэдэгт итгэлтэй байна.



Голынх нь сургагч багш Кобаяши

Хөгжлийн бэрхшээлийн салбарын холбогдох сэдвүүдээр илтгэл тавив (2019.01.28)

Сургалтын 2 дахь өдөр Монгол Улсын хөгжлийн бэрхшээлийн салбарт тулгамдаж буй асуудлуудыг Окинава мужийн багш нарт танилцуулах зорилгоор илтгэл тавилаа. Энэ удаагийн сургалтанд төрийн албан хаагч 5 хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлж 5 хүн оролцож байгаа бөгөөд өөр өөрсдийн байр сууринаас хөгжлийн бэрхшээлийн асуудлуудыг танилцууллаа. Тухайлбал, “Хууль эрхзүй, стандарт байгаа боловч хэт огцом налуу зам олон байдаг учраас тэргэнцэртэй хүн ганцаараа гадагш гарах боломжгүй”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийнхэн хүүхдээ чадваргүй гэж боддог учраас гадагш гаргадаггүй.” гэх мэтээр өнөөгийн нөхцөл байдлын талаар яриу. Нөгөөтэйгүүр “Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улс нэлээдгүй өөрчлөгдсөн. Өмнө нь ХБИ-ийг халамж хүртэгч л гэж хардаг байсан бол сүүлийн үед нийгэмд оролцох боломжууд нэмэгдэж байна. Төр болоод ХБИ-ийн хамтын ажиллагаа ч нэмэгдсэн гэж санагддаг.” хэмээн ахиц дэвшлийн талаар ч ярьж байсан юм. Оролцогчид маань энэ удаагийн сургалтаас сурч мэдсэн зүйлээ хэрэгжүүлэн ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих олон ажлуудыг хийх болно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлгүй иргэн хамтдаа амьдрахад таатай нийгмийг бүтээхийг зорилт болгох нь ... (2019.01.31)



Лекцийн үеэр

Окинава мужийн Хүүхдийн амьдрал, нийгмийн халамжийн хэлтсийн Хөгжлийн бэрхшээлийн салбар хариуцсан ажилтан Кобашигава мужийн бодлогын талаар танилцууллаа. Япон улсын тухайд улсаас баталсан хуулинд үндэслэн хот, мужаас дүрэм журам боловсруулан хэрэгжүүлж байна. Тухайлбал Хүртээмжийн хууль, Ялгаварлан гадуурхалтыг арилгах хуулийг хэрэгжүүлэхийн тулд илүү тодорхой заалтуудыг тусгасан дүрэм журам гаргасан байдаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх хамгаалагдаж байгаа юу гэдгийг шалгах үүрэгтэй байгууллагууд ч бий. Сургалтанд оролцогчид мужийн Ялгаварлан гадуурхалтыг арилгах зөвлөлийн тэргүүнээр төрийн бус байгууллагын хүн ажилладаг гэдгийг сонсоод их гайхаж байлаа. Дашрамд нь хэлэхэд энэ удаагийн сургалтыг ахалж буй Такаминэ багш тус зөвлөлийн тэргүүнээр ажилладаг юм. Өөрөөр хэлбэл Японд үнэн бодит байдлыг хангахын тулд төрөөс бус хөндлөнгийн байгууллагын ажилтан тэргүүнээр нь ажилладаг байна. Сургалтанд оролцож буй хүмүүс хууль хэрэгжих механизмыг өөрийн улстайгаа харьцуулангаа чих тавин сонсож байлаа.

Хүн нэг бүрт тохирсон аргачлалаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь (2019.02.01)

Энэ удаагийн сургалтын нэг сэдэв нь хөдөлмөр эрхлэлт юм. Японд аж ахуй нэгжид ажиллах, нийгмийн халамжийн хүрээнд ажиллах гэсэн 2 төрлөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг. Хамгийн эхэнд очиж танилцсан газар бол улсын байгууллага болох Окинава мужийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжил сургалтын төв байв. Тус байгууллага нь ХБИ-ийн аж ахуй нэгж дэх хөдөлмөр эрхлэлт, мөн ХБИ-ийг ажилд авах хүсэлтэй ажил олгогчдыг дэмжих үйл ажиллагаа явуулдаг. Ингэхдээ хүн нэг бүрт тохирсон аргачлалаар дэмжих үйл ажиллагааг явуулдаг гэж байв. Өөрөөр хэлбэл үйлчлүүлэгч хүн бүрийн чадварт нийцүүлэн дэмжих төлөвлөгөө боловсруулж дадлагажуулдаг байна. Тус төвийн дарга Кавамура “Чадахгүй зүйлийг нь бус чаддаг, боломжтой зүйлд голчлон анхаарал хандуулдаг” гэж байв. Үүнээс гадна ажлын байран дээр нь очиж дэмжлэг үзүүлэх мэргэжлийн хүнийг ч томилдог байна. Хүнд хэлбэрийн бэрхшээлтэй 1 хүнийг ажилд авсан тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй 2 хүн ажилд авсан гэж бүртгэдэг “Давхар тооцоолох (double-count)” тогтолцоо ч байдаг байна. Оролцогчид маань хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж буй Япон улсын санал санаачилгаас олон зүйлийг суралцлаа.



Лекц ба танилцах сургалтанд хамрагдав

Хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх (2018.02.11)

Японы Окинава муж нь нийслэл хотоосоо хамгийн алслагдмал зайд байдаг. Ажилгүйдлийн түвшингээрээ улсдаа нэгт ордог боловч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн хувь нь улсын дундаж үзүүлэлтээс дээгүүр байдгаараа онцлогтой. Эдийн засгийн өсөлт тийм сайнгүй ч гэлээ энэ бүс нутгийнхан ямар аргаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийнхээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллаж байна вэ? Хөтөлбөрийн хүрээнд сургалтын оролцогчид “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Саваяка төв”-ийн үйл ажиллагаатай танилцлаа. Тус төв нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн зөвөлгөө өгөх, мөн дадлага сургуулилт, ажилд орсны дараах дэмжлэгийн үйлчилгээг үзүүлдэг хувийн хэвшлийн байгууллага юм. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөдөлмөр эрхлэхэд дан ганц мэргэжил сургалт, дадлага хангалтгүй. Ажлын агуулга нь тухайн хүнд тохирч байна уу, хамт олны харьцаа хандлага хэр байна вэ гэх мэт тухайн хүн тогтвортой ажиллахад шаардлагатай дэмжлэг шаардлагатай” хэмээн тус төвийн дарга Накахара ярьж байлаа. Саваяка төвийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг аж ахуй нэгжүүдэд дадлага хийлгэх, ажилд орсны дараа ажлын байран дээр нь очиж ажил олгогч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зөвөлгөө өгөх үйл ажиллагаануудыг явуулж байна. Сургалтанд оролцогчид дээрх яриаг сонсоод ийм нарийвчилсан дэмжих тогтолцоо байгаа болохоор хөдөлмөр эрхлэлтийн хувь өндөр байгаа юм байна гэцгээж байлаа.

Оюуны бэрхшээлтэй иргэдийн ажлын байртай танилцлаа (2018.02.11)

“Сотэцү” байгууллагыг анх 30 жилийн өмнө Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооныхон байгуулжээ. Тухайн үед жижигхэн ажлын байр байсан боловч бага багаар хэмжээ нь томорч, одоогийн байдлаар 100 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлж байна. Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой сэдвийн хүрээнд олон байгууллагуудтай танилцсан хэдий ч сургалтанд оролцогчдын сэтгэлд хамгийн их нийцсэн нь энэхүү байгууллага байв. Тус байгууллага нь талх, нарийн боовны үйлдвэрлэл, нарийн ногоо тариалах, түлхүүрийн оосор, гар урлалын бүтээгдэхүүн хийх гэх мэт олон төрлийн үйл ажиллагаануудыг явуулж байна. Улмаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ аж ахуй нэгжүүдэд худалдаалж, ашиг орлогоо нэмэгдүүлж байгаа гэж байв. “Харилцагч байгууллагуудынхаа итгэлийг олохын тулд бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйд байнга хяналт тавих нь чухал” хэмээн тус байгууллагын Дэмжих хэлтсийн дарга Ахарэн ярьж байлаа. Ойр орчмынх нь айлууд Сотэцүгийн талх, нарийн боовны байнгын худалдан авагчид бөгөөд өглөө дэлгүүр нээгдэхээс өмнө аль хэдийн дугаарлан зогссон байдаг байна. Сүүлийн үед зочид буудлуудаас өглөөний цайнд хэрэглэх талхны захиалга ч орж ирж байгаа ба борлуулалт нь улам бүр өргөжсөөр байгаа гэлээ. Мөн онгоцонд ашигладаг чихэвчийг уутлах, гар утасны сэлбэг хэрэгслийг задалж ангилах зэрэг үйлчлүүлэгчдийн бэрхшээлийн түвшин, чадамжид нийцүүлэн ажлын үүргийг хуваарилдаг байна. Хүн нэг бүр нийгмийн идэвхтэй гишүүн болж ажиллаж байгаа нь сайхан санагдлаа.



Хэлтсийн дарга Ахарэн төвийн үйл ажиллагаагаа танилцууллаа

Япон соёлтой танилцлаа (2019.02.12)

Японд цагаан сарын үеэр агшааж бэлтгэсэн цагаан будааг “кинэ” гэх том модон нүүдүүрээр бяцалж иддэг Мочицүки хэмээх зан үйл байдаг. Энэ удаа сургалтанд оролцогчид маань ЖАЙКА, Окинава төвийн Мочицүки арга хэмжээнд оролцох боломж тохиолоо. Тус арга хэмжээг нээж төвийн дарга Кавасаки шинэ оны мэндчилгээ дэвшүүлсэн бөгөөд “Дэлхийн өнцөг бүрээс цугласан та бүхэнд шинэ оны мэнд хүргэе! Энэ онд та бүхний эх орон улам илүү хөгжин цэцэглэхийг хүсээд хамтдаа мочи хийцгээе” хэмээлээ. Монголоос сургалтанд оролцож буй хүмүүс ч “кинэ” нүүдүүр ашиглан мочицүки хийж үзэв. Мочи нь бөөрөнхий, цагаан өнгөтэй учраас буузтай ч төстэй харагдаж магадгүй. Гэхдээ дотроо гүзээлзгэнэтэй, улаан шоштой гээд олон янз байдаг.



Оролцогчид өөрсдийн биеэр Мочицүки хийж үзлээ

Хүн амын өндөр насжилттай холбогдуулан хотыг хүртээмжтэй болгох нь чухал (2019.02.13)



Нийтийн тээврийн хүртээмжтэй байдалтай танилцлаа

Японы хүн амын 27 хувийг 65-аас дээш насныхан эзэлдэг. Азийн бусад улс орнуудад ч өндөр насжилт нэмэгдэж байна. Та бүхэн налуу зам, бариул нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд л зориулагдсан гэж бодож байна уу? Олон улсад өндөр насжилт нэмэгдэж байгаа учраас одооноос хүртээмжтэй орчинг бий болгох нь чухал” гэж Такаминэ багш ярьж байлаа. Түүнчлэн дөнгөж шинээр баригдсан барилга хүртээмжгүй байсан учраас маш их хөрөнгө мөнгөөр засварын ажил хийсэн жишээг ч танилцуулсан юм. Угтаа бол анхнаасаа хүртээмжтэй хийчихсэн бол их хэмжээний зардал мөнгөөр засварлах шаардлагагүй. Нэг сайн жишээг танилцуулахад Наха хотын олон нийтийн тээврийн хэрэгсэл болох Монорэйлийг хийхдээ зураг төслийнх нь шатнаас л

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал бодлыг тусгасан байна. Тиймээс галт тэрэгний хаалга, буудлын тавцан хоёрын хооронд доголгүй, тэргэнцэртэй хүн ямар ч асуудалгүй бууж суух боломжтой болжээ. Мөн ихэнх автобуснууд нь шатгүй байдаг. Сургалтанд оролцогчид маань “хүний төлөө нийгмийг болгох”, хүрээлэн буй орчныг бүрдүүлэх нь ямар чухал болох, мөн Монгол Улсын цаашдын ирээдүйн талаар санал солилцлоо.

Хүртээмжтэй орчныг бүрдүүлж эдийн засгийн хөгжлийг дэмжих нь (2019.02.14)

Окинава мужийн хүн амын орлогын үзүүлэлт Японы бусад мужуудаас доогуур байдаг. Тус муж нь үзэсгэлэнт байгалаараа алдартай бөгөөд эдийн засгийн хөшүүрэг нь аялал жуулчлалын салбар юм. Улмаар “Хүн бүр амарч зугаалах боломжтой дэлхийн тэргүүлэх резорт” болох зорилгоор аялал жуулчлалын бүсүүдийнхээ хүртээмжтэй орчинг сайжруулан ажиллаж байна. Тухайлбал Дэлхийн өвд бүртгэлтэй Шюри цайзад цахилгаан шат, өргөгч лифт суурилуулсан учраас тэргэнцэртэй хүн чөлөөтэй үзэж танилцах боломжтой болжээ. Мөн Чюраүми далайн аквариумын шат, довжоотой газар бүрт налуу зам хийсэн байна. Түүнчлэн харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан дуут танилцуулга (чихэвч зүүгээд сонсдог), хүрч танилцах боломжтой брайль булангууд ч бий. Сургалтанд оролцогчид Дельфиний шоу тоглолт үзэж сонирхсон ба энэ үеэр суудал пиг дүүрэн хүнтэй байсан ч үйлчлүүлэгчид, ажилчдын ухамсар ойлголт өндөр учраас тэргэнцэртэй хүнд зориулсан зай, талбайд хэн ч суугаагүй байв. “Цаашид ч гэсэн засаж сайжруулах шаардлагатай хэсгүүд байгаа. Бид үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийн дагуу хүртээмжтэй орчныг сайжруулах ажлаа үргэлжлүүлэх болно ” гэж ярих аквариумын ажилчдын хандлага сэтгэл бахдам байлаа.



Хүртээмжтэй орчныг бүрдүүлсэн жишээнүүд

Чин сэтгэлийн нөхөрлөл (2019.02.14)

Сургалтын төлөвлөлт, зохицуулалтыг хариуцан ажилласан Эмпауэрмент Окинава (Empowerment Okinawa) ТББ-ынхан амралтын өдрөөр сургалтанд оролцогчдод зориулж хүлээн авалт хийлээ. Тус арга хэмжээнд холбогдох хүмүүсээс гадна бүс нутгийн хүүхдүүд оролцож Окинавагийн дуу, бүжгээс толилууллаа. Монголоос очсон сургалтын багийнхан ч бүгд дээл өмсөж очсон бөгөөд зохион байгуулагч талынхан монгол үндэсний хувцсыг ихэд сонирхож байв. Хүлээн авалт халуун дулаан уур амьсгалтай болж, оролцогчид ч өөр хоорондоо яриа өрнүүлэн нэг оройг хөгжилтэй өнгөрүүллээ. Сургалтын хугацаанд болсон явдлуудаас хуваалцахад оролцогч Эрдэнэзул худалдааны төвөөс байр руу гаа буцахаар таксинд суутал тэргэнцэр нь багаажинд багтаагүй байна. Энэ такси ч хүргэж өгөхгүй байх даа гэж бодтол жолооч нь хаа нэгтээгээс уяа олж авчраад, тэргэнцэрийг нь багаажиндаа хийж хаалгыг нь уяагаараа бэхэлжээ. Замдаа монгол сүмочдын талаар ярилцан хөгжилдсөөр ирсэн байна. Улмаар буух үед нь “Энэ уяа дахиад хэрэг болж магадгүй учраас аваад явж байсан нь дээр байх аа” гэж хэлээд туслах ажилчинд нь өгчээ. Энэ мэт олон сайхан хүмүүсийн ачаар Окинавад дурсамжтай цаг мөчүүдийг өнгөрүүлж чадлаа.



Өөрийнхөө амьдралыг өөрөө шийднэ – Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах эрх (2019.02.18)

“Бие даан амьдрах” гэдэг нь бүх зүйлийг өөрөө хийнэ гэсэн үг биш. Харин хэрхэн амьдрахаа өөрөө шийдэж, түүнийгээ туслах ажилтны тусламжтайгаар хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Япон улсын хувьд “Асрамжийн газарт бус өөрийн бүс нутагтаа бусдын адил амьдармаар байна” гэсэн хүсэлтийн дагуу улсаас туслах ажилтны зардлыг нь шийдэж өгөн, ХБИ-ийн бие даан амьдрах эрхийг дэмжин ажиллаж байна. Кирана бие даан амьдрах төв нь бүс нутагтаа амьдрах хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжин ажилладаг байгууллага юм. Үйлчилгээ авч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэйгээ ярилцан ямар тусламжийг хэр хэмжээнд үзүүлэх шаардлагатай талаар төлөвлөгөө боловсруулан ажилладаг. Мөн холбогдох төрийн байгууллагынханд энэ талаар ойлголт өгөх, уулзалт хийх ажлуудыг ч гүйцэтгэдэг байна. Кирана төвөөс үйлчилгээ аван, бие даан амьдарч буй Хига нь 23 жилийн өмнө зам тээврийн осолд орж хүзүүндээ гэмтэл авчээ. Тухайн үед түүнийг ээж нь асардаг байсан боловч хэт их ачаалалтай байх, нас өндөрт гарах зэрэг асуудлын улмаас асрах боломжгүй болжээ. Одоо тэрээр 24 цаг туслахын үйлчилгээ авдаг бөгөөд өдөрт 3 туслах ажилтан ээлжээр түүний гэрт нь ирдэг байна. Бие даан амьдрах төв нь туслах үйлчилгээнээс гадна далайн эрэг дээрх амралт зугаалга, хамтдаа барбекю хийх гэх мэт хөгжилтэй арга хэмжээнүүдийг ч төлөвлөн хэрэгжүүлдэг. Тус байгууллага нь тухайн бүс нутгийнхаа ард иргэдтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг холбон ажиллах гүүр болон ажиллаж байна.



Лекцийн үеэр

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санаачилгаар батлагдсан тогтоол (2019.02.19)

Энэ удаагийн сургалтаас хамгийн ихээр сэтгэлд хоногшин үлдсэн нь “Окинава мужийн хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй хүмүүс хамтдаа амьдрахад ээлтэй нийгмийг бий болгох тогтоол”-ын тухай сэдэв байлаа. Тус хичээлээр Окинава мужийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлгөөн өрнүүлж, мужийн тогтоол батлуулсан жишээг танилцуулсан юм. Дельфин бие даан амьдрах төвийн тэргүүн хатагтай Нагай “Бид ч гэсэн нийгмийн нэг гишүүн. Хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхах явдлыг арилган, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хамтдаа амьдрах нийгмийг бий болгох шаардлагатай” гэж үзэн, тогтоол батлуулах үйл ажиллагааг эхлүүлсэн байна. Улмаар эхний ээлжинд ижил зорилготой хүмүүсийг цуглуулж, тогтоол батлуулахад шаардлагатай агуулгуудаар сургалт авчээ. Мөн тэдний ажлыг дэмжин ажиллах хүмүүсийн тусламжтайгаар 7 жилийн хугацаанд тогтоолын төсөл боловсруулжээ. Үүний дараа гарын үсэг цуглуулах “Okinawa Try” үйл ажиллагааг эхлүүлсэн байна. Тэд Окинава арлыг тэргэнцэртэйгээ уртааш нь туулж, ойролцоогоор 34,000 мянган хүний гарын үсгийг цуглуулж мужийн даргад өргөн барьжээ. Ингээд 2013 онд Мужийн хурлаар тогтоолыг баталж, ирэх оных нь 4 сараас хэрэгжиж эхэлсэн байна. Энэ нь Японы Ялгаварлан гадуурхалтыг арилгах хуулиас ч өмнө иргэний хөдөлгөөний үр дүнд бий болсон түүхэнд тэмдэглэгдэхүйц үйл явдал юм. Сургалтын оролцогчид “Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг чадавхжуулахын тулд ямар үйл ажиллагааг эхлүүлэх хэрэгтэй вэ?” гэж асууж байсан бөгөөд багш “Нэг нэгээрээ үйл ажиллагаа хийхэд үр дүн багатай учраас хамт олон бүрдүүлэх, түүнчлэн хөгжлийн бэрхшээлийн төрөл хамааралгүйгээр хамтдаа нэгдэх нь чухал” гэж байлаа. Зорилгодоо хүрэхийн тулд шантралгүй тэмцэх нь чухал хэмээн ярих багшийн ярианаас оролцогчид урам зориг авлаа.



*Дельфин бие даан амьдрах төвийн тэргүүн
Нагай*

Сургалтаас сурч мэдсэн зүйлээ хэрхэн хэрэгжүүлэх вэ? (2019.02.20)

Сургалтын хамгийн сүүлийн өдөр оролцогчид Монголд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө сэдвээр илтгэл тавилаа. Өөрөөр хэлбэл сургалтаас сурч мэдсэн зүйлээ хэрхэн хэрэгжүүлэх зорилго зорилгоо бусаддаа танилцуулсан гэсэн үг. Багануур дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Гэрэлмаа Багануур дүүргийг бүх хүнд ээлтэй жишиг дүүрэг болгох хүсэлтэй байгаагаа танилцууллаа. “Төв замаа засах, ЗДТГ-ын байрыг хүртээмжтэй болгох гэх мэт хийх зүйл их байгаа боловч юуны өмнө удирдах албан хаагчид, ИТХ-ын төлөөлөгчдөд ойлголт өгөх нөлөөллийн ажлыг эхлүүлэхийг хүсэж байна.” Дүүрэгтээ Хүртээмжтэй холбоотой сургалт зохион байгуулах болно хэмээн өөрийн төлөвлөгөөний талаар ярихад бие даан амьдрах төвийн ажилтан Эрдэнэзулын хувьд “Окинава Три” хөдөлгөөний яриаг сонсоод “Монголд ч гэсэн “Три” нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулдаг. Гэхдээ цаашид Окинава мужаас суралцан, нөлөөллийн ажлуудыг эхнээс нь дуустал, эцсийн үр дүн гартал нь хэрэгжүүлэхийг хүсэж байна” хэмээн зорилгоо шинээр тодорхойлсон байв. Оролцогчид маань “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө чадавхижиж, төрийн байгууллагуудтай хэлэлцээр хийн асуудлыг шийдвэрлэх чадвартай байх”, “Хүртээмжтэй орчин бий болсноор бие даан амьдрах боломж бүрдэнэ” зэрэг олон асуудлуудыг олж харсан байлаа. Цаашид өөр өөрсдийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр хичээн ажиллана гэдэгт итгэлтэй байна.



Хаалтын үйл ажиллагаа (2019.02.20)

2 долоо хоногийн сургалт амжилттай өндөрлөж, хамгийн сүүлд нь хаалтын үйл ажиллагаа болов. Энэ үеэр ЖАЙКА, Окинава төвийн дарга Кавасаки оролцогчдод хандан үг хэлсэн ба сургалтын хүрээнд бий болгосон төр, төрийн бусын сүлжээ /network/-г ашиглан хамтдаа үйл ажиллагаа явуулахыг хүсэж байгаагаа онцоллоо. Үүний дараа бүх оролцогчдод сертификат гардуулсан бөгөөд 2 туслах ажилтанд ч сургалтанд хамрагдсан гэрчилгээ олгов. Окинава төвийн хамт олны зохион байгуулсан тус хаалтын үйл ажиллагаа маш сайхан, халуун дулаан уур амьсгалтай болж өнгөрсөн. Энэ удаагийн “Хөгжлийн бэрхшээлийн салбарын манлайлагч бэлтгэх” сургалтаас дэд бүтэц, хөдөлмөр эрхлэлт, бие даан амьдрах эрхийн өнөөгийн нөхцөл байдал төдийгүй эдгээрийг хэрхэн бий болгож ирсэн үйл явцын талаар суралцаж чадсан нь үр дүн байв. Мөн Empowerment Okinawa ТББ-ын тэргүүн, ноён Такаминэ, Дельфин бие даан амьдрах төвийн тэргүүн, хатагтай Нагай зэрэг хөгжлийн бэрхшээлтэй манлайлагчидтай танилцсанаар “Нийгмийг өөрчлөх” манлайлагч гэж ямар хүн болох талаар илүү сайн ойлголттой болж чадсан байх аа.



DPUB Холбоо барих хаяг

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: [https:// www.facebook.com/jicadpub](https://www.facebook.com/jicadpub)

Цахим хуудас: [https:// www.jica.go.jp/project/mongolia/015/index.html](https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html)

И-мэйл: dpub.jica@gmail.com